



ХӨВСГӨЛ АЙМАГ
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 09

Шарга

2015 онд ойгоос бэлтгэх модны дээд
хязгаар батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 01 сарын 22 өдрийн 03 дугаар тогтоолыг үндэслэн ИТХ-ын ээлжит IXхуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. 2015 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг 1 дүгээр хавсралтаар, бусад аймаг, суманд гаргах модны дээд хэмжээг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Ойн тухай хуульд заагдсан бүрэн эрхийн дагуу Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж хэрэгжилт, үр дүнг ИТХ-д хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Түмэнбаяр/, БОТХБТ-ын дарга /Э.Эрдэнэцэцэг/ нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин газар зохион байгуулалт хариуцсан хороонд үүрэг болгосугай.

ДАРГА Ч.АЗБАЯР



Сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2015 оны
03 дугаар сарын 02-ны өдрийн 09 тоот
тогтоолын 1 дүгээр хавсралт

Байгууллагуудын ойгоос бэлтгэх модны тоо хэмжээ, хуваарь

№	Байгууллагын нэр	Огтлолын төрөл										Бүгд дүн/м ³					Мөрөн сумын ахуйн хэрэгцээнд нийлүүлэх хэмжээ									
		Үйлдвэрлэлийн огтлолт /м3/		Арчилгааны огтлолт /м3/		Цэвэрлэгээний огтлолт /м ³ /		Цэвэрлэгээний ажил /м ³ /		Дүн		Үйлдвэрлэлийн огтлолт		Арчилгааны огтлолт		Цэвэрлэгээний огтлолт		Дүн /м ³ /		Арчилгааны огтлолт/м3/		Цэвэрлэгээний ажил/м3/		Түлээний мод/м3/		Дүн/м ³ /
1	Аймгийн хурлаас баталсан хэмжээ	Харгалээ	100	20	120	100	550	1000	1550	1500	1500	1100	3500	4600	100	550	1500	1100	3250	780	12520	200	600	400	7000	8200
2	Сумын хурал	Харгалээ	100	20	120	100	550	1000	1550	1500	1500	1100	3500	4600	100	550	1500	1100	3250	780	12520	0	300	300	3500	4100

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2015 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 09 тоот тогтоолын 2 дугаар хавсралт

Цагаан-Уул сумаас 2015 онд бусад аймаг, сум суурин газарт тээвэрлэж гадагш гаргах ахуйн хэрэгцээний болон түлшний модны дээд хэмжээ

№	баталсан байгууллага	нийт бэлтгэх модны хэмжээ /м3/						гадагш нь тээвэрлэж гаргах мод			
		Үйлдвэрлэлийн огтлолт	арчилгаагаар	цэвэрлэгээний огтлолт	цэвэрлэгээний ажил	түлээ	нийт	хувь	хэмжээ	хувь	хэмжээ
1	Аймгийн хурлаар тогтоосон хэмжээ	100	550	1500	1100	12500	15750	15%	488	5%	625
2	Сумын хурлаар	0	550	1500	1100	6000	9150	10%	315	5%	300